# 2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2014 оны 01 дүгээр сарын 20

## 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын салбартүйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

/тоогоор/

| № | Тусгай зөвшөөрөл эзэмшигчид | 2013.12.01 | Нэмэгдсэн | Хасагдсан | 2013.12.31 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Даатгалын компани | 17 | | | 17 |
| 2 | Даатгалын компанийн салбар | 241 | | | 241 |
| 3 | Даатгалын төлөөлөгч | 3164 | 61[1] | 38 | 3187 |
| 4 | Даатгалын зуучлагч | 20 | | | 20 |
| 5 | Даатгалын хохирол үнэлэгч | 12 | | | 12 |
| 6 | Актуарч | 15 | | | 15 |
| 7 | Жолоочийн даатгалын зөвшөөрөл | 16 | | | 16 |
| 8 | Даатгалын зуучлагч компанийн салбар | 39 | | | 39 |
| 9 | Даатгалын компанийн төлөөлөгчийн газар | 6 | | | 6 |

[1] Хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 289 дүгээр тушаалаар "Улаанбаатар хотын даатгал" ХХК-ийн 11 иргэнд, Хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 300 дугаар тушаалаар "Бодь даатгал" ХХК-ийн 50 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарсан байна.

## 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 12 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

**Ердийн даатгалын компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.12.31 /сарын дүн/ | 2013.12.31 /өссөн дүн/ |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Даатгалын нийт хураамж | 9 359 390 697,69 | 83 293 052 442,07 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж | 1 184 895 859,32 | 14 533 667 385,12 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 2 623 867 794,73 | 26 256 398 126,83 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр | 1 055 719 057,73 | 9 990 430 488,45 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо | 2 357,00 | 22 203,00 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 2 339 155 798,41 | 23 508 342 202,35 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 65 819,00 | 636 531,00 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо | 23 410,00 | 292 845,00 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо | 29 576,00 | 348 114,00 |
| Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 2 396 267 600 000,00 | 2 447 253 800 000,00 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр | 97 743 870,78 | 173 145 793,50 |

2013 оны 12 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 83293.0 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 14533.7 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 26256.4 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 9990.4 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирлын харьцаа сарын байдлаар 28.1 хувь, өссөн дүнгээр 31.6 хувь болсон бөгөөд өмнөх сараас 17.2 пунктээр буурсан байна.




Ердийн даатгалын компаниудын 2013 оны 12 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Мандал женерал даатгал” ХХК-ийн даатгалын 2396,2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гэрээ юм. Хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК 97,7 сая төгрөгийг олгосон байна.

**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.12.31 /сарын дүн/ | 2013.12.31 /өссөн дүн/ |
|---|---|---|
| Даатгалын нийт хураамж | 132 854 540,00 | 1 002 701 519,00 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 31 100 298,00 | 193 606 268,00 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 781 249,00 | 64 454 808,00 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 160,00 | 349,00 |
| Хувь х үний хугацаат даатгалд | 1,00 | 34,00 |
| Байгууллагын хугацаат даатгалд | 0,00 | 0,00 |
| Өндөр хамгаалалттай ЭМД-д | 0,00 | 2,00 |
| Эмнэлгийн мөнгөний даатгалд | 1,00 | 32,00 |
| Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд | 2,00 | 11,00 |
| Тэтгэврийн даатгалд | 0,00 | 6,00 |
| Орон сууцны даатгалд | 0,00 | 5,00 |
| Хуримтлалын даатгалд | 0,00 | 0,00 |
| Зээлдэгчийн амь насны даатгалд | 156,00 | 187,00 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 29,430,000.00 | 40,000,000.00 |

Урт хугацааны даатгагч 2013 оны 12 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ 1002.7 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 193.6 сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Даатгалын хохирлын харьцаа 23,4 хувьтай байгаа бөгөөд өмнөх сараас /сарын дүнгээр/ 16.9 пунктээр өссөн байна.




**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.12.31 /сарын дүн/ | 2013.12.31 /өссөн дүн/ |
|---|---|---|
| Нийт орлого | 134,732,443,328.17 | 228,095,492,296.00 |
| Даатгалын зуучлагчийн орлого | 142,637,270.17 | 1031,189,689.04 |
| Үүнээс: Сайн дурын даатгал | 52,269,782.37 | 674,530,484.73 |
| Албан журмын даатгал | 83,640,062.80 | 338,236,452.80 |
| Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж | 405,589,889.93 | 2,169,662,325.13 |
| Зуучилсан даатгалын гэрээний тоо | 10,151.00 | 47188.00 |
| Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ | 6,438,817,000.00 | 8 741 000 000,00 |

2013 оны 12 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 1031.2 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 65.5 хувийг сайн дурын даатгалаас, үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. "Асимон брокерс" ХХК-ийн зуучилсан гэрээ даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр 8741.0 сая төгрөгийн үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас "Гэрэлт буян ундрах" ХХК, "Эм жи ай би" ХХК, "Си эн эн икс" ХХК, "Төрийн банк" ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

"Монголиан интернэшнл брокерс" ХХК, "Изи инвестмэнт" ХХК, ХХК, "Эс би ай эс" ХХК, "Си эн эн икс" ХХК, "Юу ай би" ХХК-иуд тус тус 12 дугаар сарын мэдээг ирүүлээгүй байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.12.31 /сарын дүн/ | 2013.12.31 /өссөн дүн/ |
|---|---|---|
| Нийт орлого | 140 886 389,59 | 592 087 660,42 |
| Даатгалын хохирол үнэлгээний орлого | 65 263 549,82 | 320 434 456,94 |
| Үүнээс: Сайн дурын даатгал | 8 311 845,46 | 84 583 131,83 |
| Албан журмын даатгал | 20 923 535,36 | 165 757 700,11 |
| Үнэлсэн даатгалын хохирлын тоо | 1 272,00 | 14 813,00 |
| Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн | 27 634 000,00 | 27 634 000,00 |

2013 оны 12 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 320.4 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 26.3 хувийг сайн дурын, 56.8 хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

Бэст эстимэйт ХХК нь даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн болох 27.6 сая төгрөгийн үнэлгээг хийсэн байна.

“Тэгш сонголт эстимэйт” ХХК нь 12 дугаар сарын мэдээг ирүүлээгүй байна.

**БУСАД**

Хорооны 2013 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 494 дүгээр тогтоолоор “Тэнгэр даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай шийдвэр гаргасан байна.

Хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 498 дугаар тогтоолоор Хорооны 2013 оны 249, 250 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын төлбөрийн чадварыг тооцох журам”, “Ердийн даатгалын компанийн өмч сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-д тус тус нэмэлт оруулсан.

Хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Хорооны 2013 оны 271, 273 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт”, “Урт хугацааны даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-д тус тус нэмэлт оруулсан.

“Бодь даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай Хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 517 дугаар тогтоолоор, “Бодь даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай Хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 519 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрүүд гарсан байна.

Хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 520 дугаар тогтоолоор “Соёмбо даатгал” ХХК, 521 дүгээр тогтоолоор “Монгол даатгал” ХХК, 522 дугаар тогтоолоор “Мөнх даатгал” ХХК, 523 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК, 524 дүгээр тогтоолоор “Моннис даатгал” ХХК, 525 дугаар тогтоолоор “Миг даатгал” ХХК, 526 дугаар тогтоолоор “Практикал даатгал” ХХК, 527 дугаар тогтоолоор “Номин даатгал” ХХК-иуд тус тус хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулах шийдвэрүүдийг гаргуулсан байна.

**ДААТГАЛЫН ГАЗРЫН**
**БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС**